

**ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” (2020 он) хуулинд богино хугацааны буюу дөрвөн жилийн хугацаатай төлөвлөхөөр заасны дагуу Адаацаг сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт”, “Адаацагийн хөгжил сумын эдийн засаг нийгмийн цогц төлөвлөгөө 2018-2028” “Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, хөгжлийн зорилтот хөтөлбөр, аймаг, сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр, иргэдийн саналыг тусган ашигласан.

Энэхүү бодлогын баримт бичиг нь хөгжлийн тэргүүлэх 6 бүлгийг хамарч байна.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 6 бүлэг 16 чиглэл /салбар/ хүрээнд 17 зорилго, 36 зорилт 187 арга хэмжээг төлөвлөн гаргалаа.

АГУУЛГА

НЭГ.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

1.1 Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 2.1 Эрүүл мэнд
- 2.2 Биеийн тамир, спорт
- 2.3 Боловсрол
- 2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
- 2.5 Үндэсний бахархал, өв соёл

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 3.1 Санхүү, төсвийн зохицуулалт
- 3.2 Уул уурхай, ашигт малтмал
- 3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
- 3.4 Аялал жуулчлал
- 3.5 Эрчим хүч

ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ
- 4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба
- 4.3 Амар тайван, аюулгүй нийгэм
- 4.4 Батлан хамгаалах

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1 Ногоон хөгжил

ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил

АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

1.1 Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх

Зорилго: 1.1 Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Зорилт: 1.1.1 Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт, ЕБС-ийн сурагчдын теле хичээлийн хамрагдалтын хувийг 2020 онд 50.0 хувь байсныг 2024 онд 80.0 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

1.1.1.1 Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх.

1.1.1.2 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний /тоног, төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл нөөц/ бэлэн байдлыг хангах.

1.1.1.3 Эрүүл мэндийн төвийг коронавируст халдвар /сovid-19/-ын түргэвчилсэн оношлуураар хангах.

1.1.1.4 Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах.

1.1.1.5 Цар тахлын үед ЕБС-ийн сурагчдын теле хичээлийг тогтмол үзэлтийн хувийг нэмэгдүүлэх

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1 Эрүүл мэнд

Зорилго: 2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт: 2.1.1 Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийг 2020 онд 60 хувь байсныг 2024 он гэхэд 90 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.1.1.1 Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах.

2.1.1.2 “Сүрьеэгүй Адаацаг аян”-ыг өрнүүлж халдварт сүрьеэ өвчнийг бууруулах

2.1.1.3 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлнэ.

2.1.1.4 Эрүүл мэндийн төвийг эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлэх

Зорилт: 2.1.2 Эх хүүхдийн эндэгдэлгүй ажиллах

Арга хэмжээ:

2.1.2.1 Жирэмсний эрт хяналтын чанарыг сайжруулах

2.1.2.2 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх цогц үйлчилгээнд хамруулан эрүүлжүүлэх

2.1.2.3 Суурь өвчтэй дархлаа султай хоол тэжээлийн дутагдалтай 0-3 хүртэлх насны хүүхдийг зуны чийрэгжүүлэлтэнд хамруулах

Зорилт: 2.1.3 Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 86,6 хувь байсныг 2024 он гэхэд 100 хувьд хүргэж, нийгмийн хамгааллыг сайжруулна.

Арга хэмжээ:

2.1.3.1 Эмч, эмнэлгийн ажилчдын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн нэн шаардлагатай хүүхдийн эмч, уламжлалын эмч, сувилагчийг мэргэшүүлэн бэлтгэх

2.1.3.2 Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтын цахим тогтолцоог бүрдүүлж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтын эрх зүйн орчныг шийдвэрлэнэ.

2.1.3.3 Эрүүл мэндийн төвийн боловсон хүчнийг стандартын дагуу хангалтыг 100%-д хүргэх

Зорилт: 2.1.4 Эмнэлгийн ажиллах орчин тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх

Арга хэмжээ:

2.1.4.1 Амбулаторын барилгын их засварыг хийх

2.1.4.2 Эмнэлгийн ажилчдын 4 айлын орон сууц болон чийрэгжүүлэлтийн танхимыг нэгдсэн халаалтанд холбох

2.1.4.3 Оношилгоо эмчилгээний шаардлагатай тоног төхөөрөмж урвалж бодисоор хангах

2.2 Биеийн тамир, спорт

Зорилго: 2.2 Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн төвшин тогтоох сорилд хамрагдагчдыг 400-аар нэмэгдүүлж, А, В үнэлгээтэй иргэд 2020 онд 5 хувьтай байсныг 2024 онд 25 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.2.1 Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2019 онд 15 байсныг 2024 онд 50-д хүргэнэ.

Арга хэмжээ:

2.2.1.1 Иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх.

2.2.1.2 Сумын аварга шалгаруулах спортын төрөл бүрийн тэмцээн уралдааныг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах

2.2.1.3 “Алтан намар” спартикадыг нийт иргэдийн дунд зохион байгуулах

2.2.1.4 Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг зохион байгуулж хамрагдагчдыг нэмэгдүүлэх

2.2.1.5 “Бага олимп” наадамд зохион байгуулалттай оролцох

2.2.1.6 Сурын спортыг суманд хөгжүүлж байгууллага бүрт баг байгуулах

2.2.1.7 Монгол наадгай шатар, даам, шагайн спортыг хөгжүүлэх

2.2.1.8 Явган аялалыг жил бүр байгууллага иргэдийн дунд зохион байгуулах

2.3 Боловсрол

Зорилго: 2.3. ЕБСургуулийн сургалтын чанарын үнэлгээний дундажийг 2019 онд 24 хувь байсныг 2024 онд 30 хувьд, СӨБ-н хамран сургалтыг 2019 онд 79.7 хувь байсныг 2024 онд 90 хувьд хүргэнэ.

Зорилт: Төгсөлтийн шалгалтын дундаж үнэлгээ 2020 онд 70% байсныг 2024 он гэхэд 80%-д хүргэнэ, СӨБ-н сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 2021-2024 онд 80% хүргэнэ

Арга хэмжээ:

2.3.1.1 ЕБСургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим байгуулах

2.3.1.2 СӨБ, ЕБС-ийн багш нарыг дотоод, гадаадад туршлага судлуулах

2.3.1.3 “Чанартай боловсрол-Чадварлаг багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх

2.3.1.4 Насан туршийн боловсролын нэгжээр дамжуулан 9-р ангийн суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулах

2.3.1.5 Хүүхдийн дотуур байрны барилгыг шинээр барих

2.3.1.6 Дунд сургуулийг 8-24 хүний суудалтай автомашинтай болгох

2.3.1.7 Хими биологийн кабинетийг байгуулан тохижуулах

2.3.1.8 Дунд сургуулийн дотор гадна орчинг тохижуулах

2.3.1.9 Дунд сургуулийн гадна пасадны засварыг хийх

2.3.1.10 Багш ажилчдын 16 айлын орон сууцыг барьж ашиглалтанд оруулах

2.3.1.11 Багш нарын төвшин тогтоох шалгалтыг жил бүр авч хэвшүүлэх

2.3.1.12 Мэргэжлийн боловсон хүчнээр 100% хангах

2.3.1.13 ЕБС-ийг урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

Зорилт: 2.3.2 СӨБ-ын хамран сургалтыг 86,9 хувиар, ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 95 хувь байсныг 2024 онд 99 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.3.2.1 1-2 настай хүүхдийг яслийн бүлэгт хамруулах

2.3.2.2 СӨБ-ыг урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

2.3.2.3 Хүүхдийн цэцэрлэгийн гадна хашааг шинэчлэх

2.3.2.4 Хүүхдийн цэцэрлэгийн дотор гадна орчинг тохижуулах

2.3.2.5 СӨБ-н сургуульд бэлтгэгдэх 5-н настай хүүхдүүдийг бүрэн хамруулах

2.3.2.6 Хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барих

2.3.2.7 Цэцэрлэгийн бүлгийн багш нарыг хөгжим тоглох ур чадварт сургах

2.3.2.8 Хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна пасадны засварыг хийх

2.3.2.9 Багш хөгжлийн төвийг тохижуулах

2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

Зорилго: 2.4 Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт: 2.4.1 Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэний байнгын ажлын байрыг 2020 онд 10 хувь байсныг 2024 онд 30 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.4.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах

2.4.1.2 Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн бодлого, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэн ажиллах. /Эмэгтэйчүүд, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/

2.4.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны эрүүл мэнд нийгмийн хамгаалал халамж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

2.4.1.4 Албан байгууллага хамт олон хүн амын дунд архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах хорт зуршлаас сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулж архины хамааралтай иргэдэд амьдралын зөв дадалыг хэвшүүлнэ.

2.4.1.5 Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

2.4.1.6 Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэн хамтын ажиллагааг сайжруулах

2.4.1.7 Хүн амын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх

2.4.1.8 Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж 20 ажлын байр шинээр бий болгох

2.4.1.9 Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил хайж байгаа иргэдээс сул чөлөөтэй байнгын ажлын байранд 25 иргэнийг зуучилна.

2.4.1.10 Мэргэжлийн чиг баримжаа олгох төрөл бүрийн сургалтыг зохион байгуулж сургалтанд хамрагдсан иргэдийн 80-аас доошгүй хувийг ажлын байраар хангах

Зорилт: 2.4.2 Ахмад настнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлж, ахмадын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллах

Арга хэмжээ:

2.4.2.1 Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношлогоонд тогтмол хамруулах

2.4.2.2 Ахмадад ээлтэй байгууллага шалгаруулах

2.4.2.3 Ахмадын өргөөг нийтийн халаалтанд холбож үйл ажиллагааг идэвхжүүлэх

Зорилт: 2.4.3 Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах

Арга хэмжээ:

2.4.3.1 Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэн гишүүдийг чадавхжуулах сургалтанд хамруулах

2.4.3.2 Сумын хүүхдийн төлөө зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх

2.4.3.3 Хүүхдийн элчийг томилон ажиллуулах

2.4.3.4 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх төрийн болон төрийн бус хамтын үйл ажиллагааг сайжруулах

2.4.3.5 “Хүүхдийн чуулган”-ыг 2 жил тутамд зохион байгуулах

2.5 Үндэсний бахархал, өв соёл

Зорилго: 2.5 Иргэдийг соён гэгээрүүлэх, монгол өв соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэд 2020 онд 4000 байсныг 2024 онд 30000-аар нэмэгдүүлнэ.

Зорилт: 2.5.1 Соёл төвийн барилга байгууламжийг сайжруулж иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлэх тав тухтай орчин бүрдүүлнэ.

Арга хэмжээ:

2.5.1.1 Соёлын төвийн барилга шинээр барих

Зорилт: 2.5.2 Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 50 хувь байгааг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.5.2.1 Соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах

Зорилт: 2.5.3 Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2019 онд 6000 байсныг 2024 онд 30000-д хүргэнэ.

Арга хэмжээ:

2.5.3.1 Иргэдэд хүргэх соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

2.5.3.2 Сумаас төрөн гарсан нутгийн алдартан, гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулах

2.5.3.3 Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээт хамгаалагчтай болгож урамшууллыг шийдвэрлэх

2.5.3.4 Номын сангийн фондыг баяжуулах

2.5.3.5 “Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе” аяныг өрнүүлэн нийт өрхийн 80-аас доошгүй хувийн угийн бичигтэй болгож гэрчилгээ олгох

2.5.3.6 “Баг, байгууллагуудын дунд урлагийн үзлэг”-ийг 2 жил тутамд зохион байгуулах

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1 Санхүү, төсвийн зохицуулалт

Зорилго: 3.1.Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын баазыг жил бүр 2 хувиар нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтанд орон нутгийн иргэдийн бүл, аж ахуйн нэгжийн эзлэх хувийг 100 хувьд хүргэнэ.

Зорилт: 3.1.1 Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулалтыг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

3.1.1.1 Татварын тайлан буюу цахимаар ирүүлбэл зохих тайлангийн хувийг нэмэгдүүлэх

3.1.1.2 Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 100 хувь ханган биелүүлэх

3.1.1.3 Төсвийн сахилга батыг сайжруулж төсвийн өр авлагагүй ажиллах

3.1.1.4 НӨАТ-ын хууль урамшууллын системийн хүрээнд ebarimt.mn сайтыг хэрэглэгчдэд бүрэн ашиглах ажлыг зохион байгуулж бизнес эрхлэгчдийг ebarimt-д бүрэн хамруулах

3.1.1.5 Татварын бааз суурийг нэмэгдүүлэх.

3.1.1.6 Төсөв санхүүгийн ил тод байдлыг Шилэн дансны тухай хуулийн хүрээнд болон бусад хэлбэрээр зохион байгуулж иргэд олон нийтийг мэдээллээр хангах, оролцоог нэмэгдүүлэх.

Зорилт 3.1.2 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгоно.

Арга хэмжээ:

3.1.2.1 Орон нутгийн аж ахуйн нэгжүүд, иргэдийн бүлд худалдан авах ажиллагаанд цахим хэлбэрээр оролцох мэдлэг олгох сургалт зохион байгуулах

3.1.2.2. Тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймаг, сумын вэб сайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээллэх

3.1.2.3.Төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах АЗ-н сургалтанд иргэдийг хамруулж гэрчилгээжүүлэх, үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах

3.1.2.4. Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг tusuv-oron nutag.mn сайтад тухай бүр мэдээлэх

3.1.2.5 Орон нутгийн өмчийн улсын тооллогыг зохион байгуулах

3.1.2.6 Сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн Орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалт, хяналтыг сайжруулах

3.2 Уул уурхай, ашигт малтмал

Зорилго: Уул уурхайн хайгуул, ашиглалтын лицензтэй аж ахуй нэгжүүдэд хяналт тавих

Зорилт: Хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах

Арга хэмжээ:

3.2.1.1 Ашигт малтмалын лиценз эзэмшигчдийн үйл ажиллагаанд нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулах

3.2.1.2 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход орон нутгаас санал өгөх, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу шуурхай олгоход анхаарч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд тавих хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлэх

3.2.1.3 Иргэдийн оролцоотой хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, орон нутагт орох орлого татварыг нэмэгдүүлэх

3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Зорилго: 3.3 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2019 онд 71,4 сая төгрөг байсныг 2024 онд 91,4 сая төгрөгт хүргэнэ.

Зорилт: 3.3.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ 2020 онд 2 хувь байсныг 2024 онд 8-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.

Арга хэмжээ:

3.3.1.1. Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн нутгийн онцлогийг шингээсэн брэнд бүтээгдэхүүнийг дотоод гадаадын зах зээлд нийлүүлэх

3.3.1.2 Хоршоодын үйл ажиллагаа эрчимжүүлэн дэмжиж ажиллах

3.3.1.3 Орон нутагт нэн шаардлагатай жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин ажиллах /түүхий эд боловсруулах, хими цэвэрлэгээ, сүү сүүн бүтээгдэхүүн/

3.3.1.4 Уламжлалт мал маллагааны аргыг сэргээх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Мянгат малчдын зөвлөгөөн"-ийг 2 жил тутамд зохион байгуулах

3.3.1.5 Залуу малчдыг мал маллагааны арга ухаанд сургаж залуу халааг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн "Залуу малчдын чуулга" уулзалтыг зохион байгуулах

3.3.1.6 Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган эрүүл ахуйн шаардлага стандарт хангасан хүнсний бүтээгдэхүүнээр иргэдийг хангах бодлогыг хэрэгжүүлэх

3.3.1.7 Орчин үеийн стандартад нийцсэн Зочид буудал, зоогийн газар бий болгож иргэдийн санал санаачлагыг дэмжин ажиллана.

3.3.1.8 Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах

3.3.1.9 Сумын брэнд бүтээгдэхүүн борлуулах цэгтэй болох

3.3.1.10 Ар-Урт багт мал угаалгын ванн шинээр барих

3.3.1.11 Арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах

3.3.1.12 Аялал жуулчлалын малчин хөтөлбөр хэрэгжүүлнэ

3.3.1.13 Ар-Урт багт тариалангийн талбай бий болгож хивэгний үйлдвэр байгуулах

3.3.1.14 Туслах аж ахуй болох хүлэмжийг ногооны талбайд байгуулж иргэдийн ногооны хэрэгцээг хангах

3.3.1.15 Мал төхөөрөх мах боловсруулах үйлдвэр байгуулна

Зорилт: 3.3.2. Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг шинээр нэвтрүүлнэ.

Арга хэмжээ:

3.3.2.1 Нэг малаас авах ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх

3.3.2.2 Сумын хэмжээнд үхэр хонин сүргийн тоо, ашиг шимийг нэмэгдүүлэн , цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулах

3.3.2.3 Тэмээний амьдын ашиг шим /ноос, сүү, уналгаа эдэлгээ/-ийг нэмэгдүүлж, тэмээгээ өсгөсөн баг, малчдыг дэмжиж ажиллана.

Зорилт: 3.3.3. Бэлчээрийн даац хэтрэлтийг үе шаттайгаар бууруулж, Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж нөхөн сэргээх талбайн хэмжээг 2024 онд 20000 га-д хүргэнэ.

Арга хэмжээ:

3.3.3.1 Малын тэжээлийн ургамлыг 5 га талбайд тариална.

3.3.3.2 Айл өрхүүдийг өвөлжөө, хаваржааны дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж хамгаалах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх

3.3.3.3 Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулах

3.3.3.4 Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худагаар усжуулах

Зорилт: 3.3.4 Мал, амьтны халдварт празитех өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тарилгад хамрагдсан малын тоо 2020 онд нийт мал сүргийн 34.2 хувийг хамруулсан бол 2024 онд нийт малын 60%-ийг хамруулна.

Арга хэмжээ:

3.3.4.1 Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг графикт хугацаанд нь бүрэн хамруулах

3.3.4.2 Мал угаалгын ажлыг суурин ваннд жил бүр зохион байгуулах

3.3.4.3 Мал эмнэлгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж мал эмнэлгийн гэрчилгээг 100% цахимжуулна.

3.3.4.4 Малын сэг зэмийн устгалыг төлөвлөгөөт хугацаанд нь оновчтой зохион байгуулах

3.3.4.5 Сүм багт мал угаалгын ванн барих

3.3.4.6 Шинээр төгсөж байгаа болон малын эмч мэргэжилтнүүдийг орон нутагтаа ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангаж ажиллах

3.4 Аялал жуулчлал

Зорилго: 3.4 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн гадаад жуулчдын тоог жилд 300-д хүргэнэ.

Зорилт: 3.4.1 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой эвент арга хэмжээг бий болгох

Арга хэмжээ:

3.4.1.1 Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, орон нутгаа сурталчлах

3.4.1.2 Аялал жуулчлалын газруудын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн дундаж үнэлгээг 90 хувьд хүргэх

3.4.1.3 Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж иргэдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх

3.4.1.4 Аймгийн тахилгат Их Адаацагийн уулын булгийн үзэсгэлэнт газрыг тохижуулж, аймаг улсын аялал жуулчлалын нэгдсэн маршрутад холбож дотоод гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх

3.4.1.5 Сүм хөх бүрдийн бүтээн байгуулалтыг түшиглэн тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх, үйл ажиллагааг хэвийн болгон, эзэнжүүлэх

3.4.1.6 Улс, аймаг, Орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газрыг нэмэгдүүлэх

3.4.1.7 Ангийн орлогыг нэмэгдүүлэх, ан амьтдыг хамгаалах, өсгөх арга хэмжээ зохион байгуулах /шувууны суулгац, ган зудын үед өвс хужир мараа тавьж өгөх/

3.4.1.8 Хогийн цэгийг тогтмол шууж нүх дүүрсэн тохиолдолд шинээр хогийн цэг байгуулах

3.5 Эрчим хүч

Зорилго: 3.5 Цахилгааны хүчдэлийг нэмэгдүүлнэ.

Зорилт: 3.5.1 Сумын төвийн эрчим хүчний найдвартай ажиллагааг хангаж хяналт тавьж ажиллах

Арга хэмжээ:

3.5.1.1 Сумын төвийн шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах

3.5.1.2 Иргэдийг найдвартай эрчим хүчээр хангах

3.5.1.3 Ар-Урт багийн төвийг эрчим хүчээр хангах

ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ

Зорилго: 4.1 Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

Зорилт: Дижитал шилжилт хийх замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхыг 2020 онд 10 хувьтай хэрэгжиж байгааг 2024 онд 80 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.1.1.1 Сумын төвийн 4G сүлжээний сувгуудыг нэмэгдүүлнэ

4.1.1.2 Орон нутгийн удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга хэмжээг сар бүр зохион байгуулах

4.1.1.3 Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

4.1.1.4 Архивт нягтруулсан шүүгээ 1-г авч бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах

4.1.1.5 Багийн засаг дарга нарыг үе шаттай унаажуулах, сэлбэг хэрэгслээр хангах

4.1.1.6 Төрийн үйлчилгээний “Хур систем”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлэх

4.1.1.7 16 насанд хүрсэн иргэнд шинээр 25, 45 нас хүрсэн иргэдийн цахим үнэмлэхний хугацааг сунгах иргэдийн судалгааг багийн засаг дарга нартай гаргаж иргэдэд урьдчилан мэдээлж зөрчлийг арилган төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх

4.1.1.8 Архив, Албан хэрэг хөтлөлтийг шат шатанд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

4.1.1.9 Шилжиж ирж байгаа боловсон хүчнийг орон байраар хангаж, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх.

4.1.1.10 Орон нутгийн боловсон хүчний бодлогыг тодорхойлж, шаардлагатай боловсон хүчнийг гэрээгээр сургах сургалтын хөтөлбөрийг хариуцах

4.1.1.11 Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулан удирдах албан хаагчийн манлайллыг үзүүлж албан хаагчдын сургалтын хэрэгцээг хангаж мэргэшүүлэх

4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба

Зорилго: 4.2 Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчлийг бууруулна.

Зорилт: 4.2.1 Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 1 хувь байсныг 2024 онд 0 хувь болгон бууруулна.

Арга хэмжээ:

4.2.1.1 Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцсэн мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх

4.2.1.2 Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах

4.2.1.3 Бүх шатанд шийдвэр боловсруулах, батлах, хэрэгжүүлэхдээ иргэд, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн саналыг сонсох, тусгах, зөвлөлдөх, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж, оролцоог нэмэгдүүлэх

4.2.1.4 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог сайжруулж, шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх

4.2.1.5 Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хангахад чиглэсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ, сургалт, сурталчилгааг жил бүр нийт иргэдийн 20-оос доошгүй хувьд зохион байгуулах

4.2.1.6 Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн тусалцаа, үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх

4.2.1.7 Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг орон нутагт зохион байгуулах

4.2.1.8 Төрийн албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэн байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

4.2.1.9 Төрийн албан хаагчдыг ажлын байран дээрээ суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэн тасралтгүй ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах

4.2.1.10 Орон нутгийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах бодлогыг баримталж орон нутгийнхаа их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудтай гэрээ байгуулж ажиллах

4.3 Амар тайван, аюулгүй нийгэм

Зорилго: 4.3 Гэмт хэргийн гаралт 2019 онд 10 байсныг 2024 онд 70-аас доошгүй хувиар бууруулж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.

Зорилт: 4.3.1 Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан хохирлыг барагдуулах бодит нөхцөлийг дээшлүүлж, 2019 онд 70 хувьтай байгааг 2024 онд 100-аас дээш хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.3.1.1 Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлэх

4.3.1.2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

4.3.1.3 Иргэний нийгмийн байгууллагатай хамтран архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

4.3.1.4 Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлого, үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ.

Зорилт: Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

4.3.2.1 Цагдаагийн албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах

4.3.2.2. Суманд ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, цагдаагийн үйл ажиллагааг дэмжин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг иргэдэд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн хүнийг ажлын байраар хангах

Зорилт: 4.3.3 Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2020 онд 60 хувьтай байсныг 2024 онд 80 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.3.3.1 Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах техникийн бэлэн байдлыг хангах

4.3.3.2.1 Гамшгаас хамгаалах ангиллын сургалтанд орон нутгийн нийт хүн амын 30 хувийг хамруулах

4.3.3.3 Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж суманд дадлага сургууль үзлэг зохион байгуулах

4.3.3.4 Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах бэлтгэл бэлэн байдлын нөөцийг ханган ажиллана.

4.4 Батлан хамгаалах

Зорилго: 4.4 Орон нутгийн батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

Зорилт: 4.4.1 Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадамж 2020 онд 80 хувь байсныг 2024 онд 90 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

4.4.1.1 Ахлах ангийн сурагчдад "Эх оронч" үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулах, Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний сургалтын тогтолцоог бэхжүүлэх, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэн нөөцийг бүрдүүлэх

4.4.1.2 Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах.

4.4.1.3 Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг тухайн жилийн орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах

4.4.1.4 Цэрэг татлагыг жил бүр зохион байгуулж хяналтын тоог хангаж ажиллах

4.4.1.5 Цэрэг татлагаас эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн иргэдийг ээлжит татлагын хооронд эрүүлжүүлэх ажлыг шат дараалалтайгаар зохион байгуулна.

4.4.1.6 Цэргийн тоо бүртгэлийг жил бүр зохион байгуулж тайлан мэдээг аймгийн цэргийн штабт хүргүүлэн ажиллах

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1 Ногоон хөгжил

Зорилго: 5.1.1 Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт: Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг бууруулна.

Арга хэмжээ:

5.1.1.1 Сумын төвийн айл өрхүүдийн хашаанд хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав суурилуулна

5.1.1.2 Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

5.1.1.3 Цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөн ногоон төгөл болгох

Зорилт: 5.1.2 Усны бохирдол, хомстлоос сэргийлж, шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

5.1.2.1 Ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 2 эх үүсвэрт суурилуулах

5.1.2.2 Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах

5.1.2.3 Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт нь тухай бүр нь нөхөн сэргээлт хийлгэх

Зорилт: 5.1.3 Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдах айл өрхийн эзлэх хувь 2020 онд 0 байсныг 2024 онд 20 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

5.1.3.1 Аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлэх

Зорилт: 5.1.4 Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 5 га байгааг 2024 онд 10 га-д хүргэнэ.

Арга хэмжээ:

5.1.4.1 Сумын хэмжээнд 5 га талбайд ойн зурвас байгуулах

Зорилт: 5.1.5 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 11 хувь байсныг 2024 онд 25 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

5.1.5.1 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах

ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил

Зорилго: 6.1 Дэд бүтцийг хөгжүүлэн, инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцыг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Зорилт: 6.1.1 Иргэдийн оролцоотой "Жишиг сум" хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ:

6.1.1.1 Сумын төвд усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах

6.1.1.2 Сумын төвийн баруун талд өмчлөлийн газарт цахилгааны эх үүсвэрийг татах, ундны усны асуудлыг шийдвэрлэх

6.1.1.3 Жишиг гудамж төсөл, тохижилтын ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх

6.1.1.4 Сумын төвийн ундны усны худгуудад хамгаалалтын бүс тогтоож, цэвэршүүлэх төхөөрөмж болон SMART худгийн тоног төхөөрөмж суурилуулна.

6.1.1.5 Сумын төвийн хүүхэд залуучуудын талбайд чийрэгжүүлэлтийн төхөөрөмж суурилуулна.

6.1.1.6 Хогийн автомашины парк шинэчлэлт хийх

6.1.1.7 Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгах, дахин төлөвлөх

6.1.1.8 Иргэдийг зээлийн хөнгөлөлттэй нөхцөлтэй орон сууцанд амьдрах боломжийг бий болгож 12 айлын орон сууц барих

6.1.1.9 Хүүхдийн тоглоомын талбайг үе шаттай тохижуулан орчин үеийн тоглоомоор хангах, хүүхэд багачуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

6.1.1.10 Байгууллагуудын цахилгааны монтажийг засварлан шинэчлэх

6.1.1.11 Газрын хилийн маргааныг шийдвэрлэнэ.

Зорилт: 6.1.2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангах үүднээс санал авсан иргэдийн тоо 2020 онд 570 байсныг 2024 онд 720 болгон нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

6.1.2.1 ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээг олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн тоог нэмэгдүүлэх.

6.1.2.2 Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг tusuv-oron.nутаг.mn сайтад тухай бүр мэдээлэх.